

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

ХАДГАЛАМЖИЙГ ОРЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ
2017 ОНЫ 8 САР №1

ӨНДӨР ХҮҮ

ХАДГАЛАМЖИЙН ХҮҮНЭЭС
30%-ИАР ӨНДӨР ХҮҮТЭЙ

ТАТВАРГУЙ

10%-ИЙН ТАТВАРААС
ЧӨЛӨӨЛӨГДӨНӨ

ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ

ХУГАЦАА ДУУСАХААС ӨМНӨ
ТОРГУУЛИГУЙГЭЭР ЦУЦЛАХ
БОЛОМЖТОЙ

НАЙДВАРТАЙ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ТУЛ
ХАМГИЙН НАЙДВАРТАЙ

**537 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД
536.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН
ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД
ХУДАЛДАЖ АВСАН БАЙНА

**100 МЯНГАН
ТӨГРӨГ**

НЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН
НЭРЛЭСЭН ҮНЭ 100,000 ТӨГРӨГ
БАЙНА

**11.7% -ИЙН
ХҮҮ**

ЗАСГИЙН ГАЗРЫН 3 САРЫН
ХУГАЦААТАЙ БОНДЫН ХҮҮ 11.745%
БАЙНА

**80.9 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД 80.9 ТЭРБУМ
ТӨГРӨГИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД
ЗАРЖ, ХУГАЦААНААС ӨМНӨ МӨНГӨӨ
БУЦААЖ АВСАН БАЙНА

**6 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД 6 ТЭРБУМ
ТӨГРӨГИЙН КОМПАНИЙН БОНД
ХУДАЛДАЖ АВСАН БАЙНА

17.5%

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ДЭЭР ЗАРАГДАЖ БУЙ КОМПАНИЙН
БОНДЫН ХҮҮ 17.5%-ТАЙ БАЙНА

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД ГЭЖ ЮУ ВЭ?

ҮНЭТ ЦААС

ЗАСГИЙН ГАЗРААС ТОГТООСОН ХУГАЦАА ДУУСМАГЦ ХҮҮ БОЛОН ҮНДСЭН ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХИЙГ АМЛАСАН ӨРИЙН БИЧИГ ЮМ.

ЗОРИЛГО

ТӨРИЙН САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙГ УДИРДАХ ЗОРИЛГООР БОНД ГАРГАДАГ.

ХУГАЦАА

3 САР, 6 САР, 9 САР, 1 ЖИЛ, 2 ЖИЛ, 3 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААТАЙ БАЙДАГ.

ДАВУУ ТАЛ



30%-ИАР ӨНДӨР ХҮҮТЭЙ

Та 3 сарын хугацаатай Засгийн Газрын бонд худалдаж аваад жилийн 11.745 хувийн хүү авах боломжтой. Энэ нь банкны хүүнээс даруй 30 хувиар өндөр байна.



10%-ИЙН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨГДӨНӨ

Та Засгийн Газрын бондод хөрөнгө оруулалт хийснээр түүнээс авах хүүгийн орлогод татвар төлөхгүй.



ХӨРВӨХ ЧАДВАР ӨНДӨР

Хугацаа нь дуусахаас өмнө та бондоо зарсан тохиолдолд аливаа торгуулигүйгээр хүү болон үндсэн төлбөрөө авах боломжтой.



НАЙДВАРТАЙ

Засгийн Газрын бонд нь улсын төсвийн хөрөнгөөр баталгааждаг хамгийн найдвартай, эрсдэлгүй санхүүгийн хэрэгсэлд тооцогддог.

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ХҮҮГИЙН ХАРЬЦУУЛАЛТ (3 САРЫН ХУГАЦААТАЙ)

ХАДГАЛАМЖ
ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД
КОМПАНИЙН БОНД

10.066%
11.745%
23.0%

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ХҮҮГИЙН ХАРЬЦУУЛАЛТ (1 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ)

ХАДГАЛАМЖ
ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД
КОМПАНИЙН БОНД

14.533%
11.845%
17.5%

Та 3 сарын хугацаатай Засгийн Газрын төгрөгийн бонд худалдаж аваад жилийн 11.745 хувийн хүү авах боломжтой. Уг бондын хүүгийн орлогоос татвар төлөхгүй бөгөөд энэ нь банкны хүүнээс даруй 30 хувиар өндөр байна.

Жилийн хугацаатай Засгийн Газрын төгрөгийн бондын хүү бага байгаа бол Компанийн бондын хүү 17.5 хувь байна. Энэ нь банкны хүүнээс 20.4 хувиар өндөр байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР ХАМГИЙН ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

2017.08.31

2016 оны 8 сарын байдлаар олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголд үйл ажиллагаа явуулдаг доорх уул уурхайн компанийн хувьцаа өссөн байна.

МОНГОЛИЯ МАЙНИНГ КОРПОРАЦИ

0.28 HKD

Ханш

127.3%

Жилийн өөрчлөлт



-10.7%

Сарын өөрчлөлт

ПЕТРО МАТАД

10.25 GBP

Ханш

305.9%

Жилийн өөрчлөлт



2.7%

Сарын өөрчлөлт

ТУРКОЙЗ ХИЛЛ РЕСОРС

4.1 CAD

Ханш

4.2%

Жилийн өөрчлөлт



20.8%

Сарын өөрчлөлт

ЭНТРИ ГОУЛД

0.66 CAD

Ханш

52.6%

Жилийн өөрчлөлт



52.6%

Сарын өөрчлөлт



2017 ОНЫ 8 САРД МОНГОЛИЯ МАЙНИНГ КОРПОРАЦИЙН ХУВЬЦАА ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД 127.3%-ИАР ӨССӨН

Тус компани нь Хонг Конгийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй бөгөөд Монголд Ухаа Худаг болон Баруун Наран коксжих нүүрсний уурхайг эзэмшдэг компани юм. 2017 оны хагас жилээр компанийн нүүрс олборлолт болон борлуулалт нэмэгдэж, санхүүгийн үзүүлэлт огцом сайжирсан нь компанийн хувьцааны ханшийн өсөлтөд нөлөөсөн байна. Тухайлбал, 2017 эхний хагас жилд компани болон түүний охин компаниуд нийтдээ 4.2 сая тонн нүүрс олборлож, 2.3 сая тоннын нүүрсний төрлийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна. Нүүрсний борлуулалт нэмэгдсэн нь компанийн нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 691.7%-иар нэмэгдүүлж, 245.9 сая долларт хүргэсэн байна. Өнгөрсөн оны мөн үед компани нь 33.6 сая долларын алдагдалтай ажиллаж байсан бол энэ оны хагас жилийн байдлаар 110.6 сая долларын ашигтай ажилласан байна.

ВАЛЮТЫН ХАНШ 2017.08.31

| ВАЛЮТ | | ХАНШ | % ЖИЛ | % САР |
|-------|--------|----------|-------|-------|
| USD | ДОЛЛАР | 2,430.05 | 9.48 | 0.61 |
| EUR | ЕВРО | 2,889.33 | 16.88 | 0.77 |
| CNY | ЮАНЬ | 368.43 | 10.87 | 1.40 |
| RUB | РУБЛЬ | 41.50 | 22.02 | 2.22 |

2017 оны эхнээс тогтвортой буурч байсан долларын ханш 7 сараас өсч эхэллээ. Долларын ханш 2017.08.31-ний байдлаар 2,430.05 төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.48%-иар өссөн байна. Энэхүү өсөлт нь сонгуулиас үүдэлтэй зах зээлд үүссэн тодорхой бус байдал цаашлаад улс төрийн тогтворгүй байдалтай холбоотой юм. Тухайлбал, сонгуулийн дараагаас эхлэн долларын ханш чангарах нь гэх хүлээлт хүмүүсийн дунд үүссэн байна. Гэвч Монгол Банкнаас сар бүр зарладаг хэвлэлийн бага хурлаас манай валютын орох урсгал маань гарах урсгалаас их байгаа тул макро суурь хүчин зүйлтэй харьцуулж үзвэл төгрөгийн ханш сулрах нөхцөл үүсээгүй байгаа талаар мэдэгдлээ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР ХАМГИЙН ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

2017.08.31

ХУВЬЦААНЫ ӨСӨЛТ

| ХАМГИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА | ХАНШ | ▲% ЖИЛ | ▲% САР |
|--------------------------|--------|--------|--------|
| ТАВАН ТОЛГОЙ | 7,640 | 446% | 43% |
| ГОВЬ | 15,000 | 79% | 8% |
| МОНГОЛ ШУУДАН | 385 | 37% | 1% |
| АПУ | 452 | 12% | 17% |
| СҮҮ | 160 | 21% | 17% |



ТАВАН ТОЛГОЙ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ХАНШ 7,640 ТӨГРӨГТ ХҮРЧ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 446%-ИАР ӨСЧ ХАМГИЙН ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ БАЙЛАА

Тус компани нь 2017 онд нэгж хувьцаандаа 872 төгрөг буюу нийт хувьцаа эзэмшигчиддээ 45.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан байна. Мөн 2017 оны хагас жилийн байдлаар Таван Толгой компанийн борлуулалтын орлого 255 тэрбум төгрөг, нийт ашиг 57.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь 2016 оны жилийн эцсийн ашгаас давсан үзүүлэлт гэдгийг онцлох хэрэгтэй юм.



АПУ ХК БОЛОН ХАЙНЕКЕН КОМПАНИ МОНГОЛ ДАХЬ АРХИ, ШАР АЙРГИЙН БИЗНЕСЭЭ НЭГТГЭХЭЭР ХАРИЛЦАН ТОХИОЛЦООД БАЙНА

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд 2017.08.18-ны өдөр АПУ ХК хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж, хурлаараа Эвэргрийн Инвестментс ХХК-ийг өөртөө нэгтгэх замаар компани өөрчлөн байгуулахаар шийдвэрлээд байгаа билээ. Тодруулбал, Хайнекен Интернэйшнл болон MCS группын хамтарсан хөрөнгө оруулалттай М Би Си компанийг Эвэргрийн Инвестментс компанитай нийлүүлж, Эвэргрийн Инвестментс ХХК-ийг АПУ-тай нэгтгэх юм. Монголын дотоодын шар айргийн зах зээлийн 62 хувийг, архины зах зээлийн 50 хувийг эзэлж буй АПУ ХК нь дэлхийн хэмжээнд бизнес эрхэлдэг Хайнекен компанитай түншилснээр бүс нутгийн гол тоглогч, Монголын брэнд бүтээгдэхүүнийг Ази болон олон улсын бусад зах зээлд түгээгч болох хөгжлийн шинэ шатанд гарах юм.



МОНГОЛ ШУУДАН ХК НЬ 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ 603.6 СЯА ТӨГРӨГИЙН ЦЭВЭР АШИГТАЙ АЖИЛЛАСАН БӨГӨӨД ЭНЭ НЬ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 3.1 ДАХИН ӨССӨН БАЙНА

Монгол Шуудан ХК-ийн орлого өсөхөд шуудангийн үндсэн үйл ажиллагааны орлого, транзит шуудан болон хүүгийн орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Гадаад шуудангийн урсгалаас ойролцоогоор нэг сая орчим долларын орлого олдог тус компанийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэн ОХУ болон БНХАУ-ыг холбосон транзит шуудангийн үйлчилгээг туршиж эхэлсэн бөгөөд энэ үйлчилгээг нэвтрүүлснээр олох орлогоо 2-4 дахин нэмэгдүүлэх боломжтой гэж харж байгаан байна.



ГЕРМЕС ЦЕНТР ХК 2017 ОНД 2 УДАА НОГДОЛ АШИГ ТАРААЛАА

Гермес Центр ХК нь 2017 оны 1 сард хувьцаа эзэмшигчиддээ 320 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол сая 8 сард дахин 300 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар боллоо. Тус компани нь Баянгол дүүрэгт үйлчилгээний төв түрээсэлдэг болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР ШИНЭ ХУВЬЦААТ КОМПАНИ БҮРТГҮҮЛЖ, ХУВЬЦААГАА АРИЛЖААЛАХААР БОЛЛОО

Айтүүлс ХК нь 2017 оны 9 сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрлөө авч, 13.4 сая ширхэг хувьцаагаа нэг бүрийг нь 100 төгрөгөөр олон нийтэд санал болгон зарахаар боллоо.

Компани нь шинээр хувьцаа гарган 1.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээр Дархан хотод Модуляр дата төвийн парк байгуулахад зарцуулах юм.

ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

| | |
|----------------------|-------------------------|
| ХУВЬЦАА ГАРГАГЧ | АЙТҮҮЛС ХК |
| НЭГЖ ХУВЬЦААНЫ ҮНЭ | 100 ТӨГРӨГ |
| САНАЛ БОЛГОХ ХУВЬЦАА | 13,387,980 ШИРХЭГ |
| НИЙТ ҮНИЙН ДҮН | 1.3 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| ХУВЬЦААНЫ АРИЛЖАА | МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ |

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД (САЯ ТӨГРӨГ, 2016.12.31)

| | |
|---------------------|---------|
| БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО | 474.9 |
| ЦЭВЭР АШИГ | 18.3 |
| ХӨРӨНГӨ | 1,618.3 |
| ӨР ТӨЛБӨР | 197.8 |
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | 1,420.5 |

Айтүүлс ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан программ хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус компанийн үндсэн үйлчилгээ нь интернэтийн техологид суурилсан дата төвийн үйлчилгээ бөгөөд 2015 онд TIER II стандартын шаардлагыг хангасан дата төвийг Улаанбаатар хотод байгуулан ажилласан байна. Одоогоор Айтүүлс ХК нь 4,000 орчим вэбсайтыг уг төвдөө байршуулан, 3,700 гаруй харилцагчдад үйлчилгээ үзүүлж байна.

Тус компани нь 2016 онд 474.9 сая төгрөгийн орлогтой ажиллаж, 18.3 сая төгрөгийн ашиг олсон байна. Компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлснээр 2017-2021 оны хооронд нийт 10.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 4.06 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, төслийн эцэст 4.99 тэрбум төгрөгийн ашиг хуримтлуулахаар төлөвлөж байна.

АРД СЕКЮРИТИЗ ҮЦК ХХК

Ард Секюритиз компани нь 1997 онд байгуулагдсан тэргүүлэх үнэт цаасны компанийн нэг юм. Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд андеррайтер, брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

ДАВУУ ТАЛ

ШИМТГЭЛ

Бид танд хамгийн бага шимтгэлийг санал болгож байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ШИМТГЭЛ: 0.03%

СУРГАЛТ

Бид үнэт цаасны зах зээлд оролцох болон ашигтай компанийг хэрхэн таних талаар иргэд болон албан байгууллагын ажилчдад зориулан сургалт явуулж байна.

ХАМГИЙН ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

Бид сүүлийн үеийн өгөөж өндөр санхүүгийн хэрэгслийн мэдээллийг танд өгнө.

ХУВЬЦАА, ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Хувьцаа болон Засгийн Газрын бонд худалдаж авах, худалдахад зуучилна.

ХУВЬЧЛАЛЫН ЦЭНХЭР, ЯГААН ТАСАЛБАР

Хувьчлалаар Монгол Улсын иргэдэд өгсөн цэнхэр ягаан тасалбарын талаар мэдээлэл өгнө.

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК

Монгол Улсын иргэн бүр эзэмшиж буй Эрдэнэс Таван Толгой ХК-ийн талаар хамгийн сүүлийн үеийн мэдээллийг бид өгсөн.



Ард Секюритиз компани нь үнэт цаасны зах зээлд оролцож, амжилтанд хүрч байсан хүмүүсийн мэдлэг, туршлагаас хүргэх зорилгоор ХасБаян-Өлзийт хадгаламж зээлийн хоршооны захирал Давхарбаяртай уулзаж ярилцлаа. Давхарбаяр нь 2013 оноос хувьцаа, бонд худалдаж авч, хөрөнгийн зах зээлийн талаар сонирхож эхэлсэн юм байна.

Та өөрийнхөө талаар бидэнд танилцуулна уу?

Би Хэнтий аймгийн Өлзийт сумын бүрэн дунд сургуулийг 1992 онд онц дүнтэй төгсөөд Цэргийн Их Сургуульд урилгаар орсон. 2 жил сураад ар гэрийн гачигдлаас болоод сургуулиа орхьсон. Манай сум газар тариалангийн бүс нутаг л даа. Гэтэл тухайн үед газар тариаланд банкууд зээл олгодоггүй, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр байсан. Тиймээс газар тариаланд зээл олгох зорилгоор сумынхаа иргэдтэй хамтран ХасБаян-Өлзийт хадгаламж зээлийн хоршоог байгуулж, одоог хүртэл үйл ажиллагааг нь тогтвортой явуулж байна.

Хэзээнээс үнэт цаасны зах зээлийн талаар сонирхож болов?

Ер нь үнэт цаасны зах зээлийн талаар мэдлэг муу, ойлгодоггүй байсан. 1990-ээд онд цэнхэр ягаан тасалбар өгч байхад манай гэрийнхэн тэр тасалбараар хувьцаа авах нь хэрэгтэй гэж мэдээ ч үгүй, гурил будаанаас л өгч орхисон. Харин 2013 онд Ганхуяг захиралтай танилцаж, хувьцааны талаар мэдээлэл авсан. Тухайн үед Хас Банкны ажилчид банкныхаа хувьцааг 100 төгрөгөөр аваад, 10,000 төгрөгөөр зарсан талаар сонссон. Үүнээс үүдэн хувьцаа авах санаа төрсөн.

Хувьцаанаас хамгийн их ашиг олсон тохиодлоосоо хуваалцахгүй юу?

2016 онд найз маань Монголия Майнинг Корпораци компанийн хувьцааг авах хэрэгтэй гэж зөвлөсөн. Ингээд Ард Секюритиз үнэт цаасны компанитай очиж уулзаад тус компанийн талаар мэдээллийг авсан. Тухайн үед нэг хувьцааг нь 0.02 хонг конг доллароор аваад хэдэн сарын дараа 0.2 хонг конг доллароор зарсан. 10 дахин өссөндөө. Бас Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааг 1,000 төгрөгөө авсан. Одоо нэгж хувьцаа нь 2,300 төгрөгтэй явж байна. бараг 1.3 дахин их ашиг хийгээд байна.

Хувьцаагаа яаж сонгодог вэ, үнэ нь өснө гэдгийг яаж мэддэг вэ?

Сонирхож байгаа компанийнхаа талаар мэдээллийг Ард Секюритизээс авч, хувьцаа авах шийдвэрээ гаргадаг. Мөн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал их чухал. Та хувьцааг нь авсан компанийнхаа хувьцаа эзэмшигчдийн хуралд байнга сууж, компанийнхаа үйл ажиллагааны тайлантай танилцаж, гол шийдвэр гаргалтад оролцож байх хэрэгтэй. Эндээс л таны хувьцааны үнэ өсөх эсэх нь харагдах юм.

Хувьцаа авч, үнэ нь өсөхөөр зарж ашиг хийдэг юм байна. Өөр ямар давуу талтай вэ?

Компани ашигтай ажиллавал ногдол ашиг тараадаг. Сая л гэхэд Таван Толгой компани нэгж хувьцаандаа 872 төгрөг буюу нийт хувьцаа эзэмшигчиддээ 45.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан байна шүү дээ.

Засгийн газрын бонд худалдаж авч байсан гэсэн. Энэ талаар мэдээллээ хуваалцахгүй юу?

2017 оноос хадгаламжийн хүүнээс татвар авч эхэлсэн. Энэ үеэс мөнгө хадгалах өөр ямар боломж байна гэж сонирхож болсон. Гэтэл Засгийн Газрын бонд гэж хамгийн эрсдэл бага, хүү өндөр, орлогын татваргүй гээд олон давуу талтай бүтээгдэхүүн олж мэдсэн. Хамгийн гол нь арилжааны банкууд хүртэл Засгийн Газрын бонд худалдаж авч байна. Сая 2017 оны эхээр Засгийн Газрын бондын жилийн хүү 17.9 хувьтай, хамгийн өндөр хүүтэй аюулгүй бүтээгдэхүүн байлаа шүү дээ.

Засгийн газрын бонд гэж юу вэ?

Анх засгийн газрын бонд гэхээр мундаг мөнгөтэй хүмүүст л хамаатай гэхээс цааш ойлголт байгаагүй. Гэтэл засгийн газрын бонд гэдэг чинь банкны хадгаламжтай ижилхэн л бүтээгдэхүүн юм байна лээ. Ялгаа нь гэвэл банк хадгаламж гэсэн нэрийн дор хүмүүсээс хүүтэй мөнгө авч зээл хэлбэрээр гаргадаг. Харин Засгийн Газар бонд гэсэн нэрийн дор хүмүүсээс хүүтэй мөнгө авч шаардлагатай үйл ажиллагаандаа зарцуулаад тодорхой хугацааны дараа буцааж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл, Засгийн Газар ард иргэдээс мөнгө зээлж аваад тодорхой хугацааны дараа буцааж ард иргэддээ төлж байгаа.

Сүүлийн үгийг танд үлдээе

Хүн ер нь ажил хийхээс гадна орлогын нэмэлт эх үүсвэртэй байх хэрэгтэй гэж санагдсан. Дэлхийн алдартай тэрбумтнууд “Чи унатаж байхдаа л мөнгө олох арга олохгүй бол үхэх хүртлээ ажиллана” гэж хэлсэн байдаг. Энэ үгийг үнэн гэж боддог. Иймээс цалингаасаа гадна нэмэлт орлоготой болох замаар хувьцаа, бонд авч эхэлсэн, үүнийхээ үр шимийг одоо харж байна. Хүмүүст хандаад мөн үнэт цаасны зах зээлийг сонирхоод үзээрэй гэж хэлье дээ.

